



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.3-1.4 дэх заалтууд, “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого”-ыг үндэслэн, хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн мэргэжилтний сэлгэн ажиллуулах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт, эмнэлгийн мэргэжилтнийг сэлгэн ажиллуулах талаар эрүүл мэндийн байгууллагуудын байгуулах хамтын ажиллагааны гэрээний загварыг боловсруулж, мөрдүүлэх, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эрүүл мэндийн газар (Ш.Энхбат)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...5... сарын ...9... өдрийн
...162... тоот тушаалын хавсралт

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

1. Ерөнхий зүйл

1.1 Хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх зорилгоор төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүд болон аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг сэлгэн ажиллуулах (цаашид "сэлгэн ажиллуулах" гэх)-тай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дангаар, багаар мэргэжлийн дагуу харилцан сэлгэн ажиллуулж болно.

1.3 Сэлгэн ажиллуулах хугацаа 1 сараас доошгүй байна.

1.4 Сэлгэн ажиллуулах мэргэжилтний мэргэжлийн чиглэл, тоо, ажиллах хуваарийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд болон аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд хамтын ажиллагааны гэрээ байгуулах замаар харилцан тохиролцно.

2. Сэлгэн ажиллах хэлбэр, зохион байгуулалт

2.1 Дараахь хэлбэрээр сэлгэн ажиллуулж болно. Үүнд:

2.1.1 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн мэргэжилтэн дангаар, багаар аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт ажиллах

2.1.2 Аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн мэргэжилтэн дангаар, багаар төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг дагалдан ажиллах

2.1.3 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төв ба аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн мэргэжилтэн дангаар, багаар харилцан солилцож ажиллах

2.1.4 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд харилцан тохиролцож, хамтарсан баг гаргаж болно.

2.2 Эмнэлгийн мэргэжилтнүүдийг сэлгэн ажиллуулахтай холбоотой гарах зардлыг дараахь байдлаар олгоно. Үүнд:

2.2.1 Сэлгэн ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн цалинг үндсэн байгууллага хариуцна.

2.2.2 Улаанбаатар хотоос орон нутагт, орон нутгаас Улаанбаатар хотод сэлгэн ажиллах эмнэлгийн мэргэжилтнүүдийн томилолтын зардлыг үндсэн байгууллага хамтын ажиллагааны гэрээнд тусгасан захиалгыг үндэслэн байгууллагын төсөвт тусгаж, олгоно.

- 2.2.3 “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь мэргэшүүлэх болон давтан сургалтын зардал, төлбөрийн жишиг”, “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн төгсөлтийн дараахь мэргэшүүлэх болон давтан сургалтыг төрөөс санхүүжүүлэх журам”-д тус тус нийцүүлэн аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт сэлгэн ажиллах төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн мэргэжилтэнд багц цагаар тооцсон сургалтын төлбөр төлж болно.
- 2.2.4 Сэлгэн ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэнд урамшуулал болон бусад нэмэлт санхүүжилтийг хамтын ажиллагааны гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу төв.эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд олгож болно.

3. Сэлгэн ажиллахад баримтлах үндсэн зарчмууд:

3.1 Сэлгэн ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт бусад дүрэм журмыг чанд баримтална.

3.2 Эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн мэргэжилтэн сэлгэн ажиллуулах үйл ажиллагааг үйлчилгээний ачаалалд нийцүүлэн, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг алдахдуулахгүй байдлаар зохион байгуулна.

3.3 Эмнэлгийн мэргэжилтнийг сайн дурын үндсэн дээр сэлгэн ажиллуулах ба сэлгэн ажиллах эмнэлгийн мэргэжилтэн бүртэй үндсэн байгууллага ба сэлгэн ажиллуулах байгууллага сэлгэн ажиллах хугацаанд гүйцэтгэх чиг үүрэг, хүлээгдэж буй үр дүн, хүлээх хариуцлага, гарах зардлын нөхөн төлбөр зэрэг асуудлыг тусгасан гурвалсан гэрээ байгуулна.